

ГАРЧИГ

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА:	3
1.1. Ерөнхий мэдээлэл	4
1.2. Төслийн байршил	5
1.3. Уурхайн жилийн хүчин чадал, горим ба ашиглалтын хугацаа	6
2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА:	8
2.1. Байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга	
3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ:	12
3.1. Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт	12
4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ:	14
5. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ:	15
6. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ:	18
7. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ:	19
8. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ:	19
9. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ:	20
10. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ:	21
11. ХОГ, ХАЯГДАЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ:	22
12. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР:	23
13. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ:	24

**14. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧИДАД ТАЙЛАГНАХ
ТӨЛӨВЛӨГӨӨ.....25**

15. “ТЭР БУМ МОД” ХӨДӨЛГӨӨНИЙ ХҮРЭЭНД МОД ТАРИХ.....26

ХҮСНЭГТҮҮД

**Хүснэгт 1.Төслийн талбайн булангийн
цэгүүд.....5**

**Хүснэгт 2. Ил уурхайн хүчин чадал ажиллах
горим.....6**

**Хүснэгт 3. Төслийн байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх гол болон
болзошгүй сөрөг
нөлөөлөл:.....12**

**Хүснэгт 4. 2026 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн
төлөвлөгөөний**

зардал:.....14

**Хүснэгт 5. Төслийн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, арилгах,
бууруулах
арга**

хэмжээ:.....15

**Хүснэгт 6. Төслийн талбайд техникийн нөхөн сэргээлт хийх арга
хэмжээ:.....18**

**Хүснэгт 7. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга
хэмжээ:.....19**

**Хүснэгт 8. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний
төлөвлөгөө:.....20**

**Хүснэгт 9. Осол эрсдэлийн менежментийн
төлөвлөгөө:.....21**

**Хүснэгт 10. Хог, хаягдлын менежментийн
төлөвлөгөө:.....22**

**Хүснэгт 11. Орчны хяналт шинжилгээний
хөтөлбөр:.....23**

**Хүснэгт 12. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг
хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын
төлөвлөгөө.....24**

**Хүснэгт 13. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний
биелэлтийг
нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах
төлөвлөгөө.....25**

ЗУРАГНУУД

Зураг 1. Төслийн талбайн байршлын	
зураг:.....	5
Зураг 2. Завхан аймгийн уул	
зүй:.....	8
Зураг 3. Завхан аймгийн усны ай	
сав:.....	10

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Завхан аймгийн Ургамал сумын нутагт орших “Зүүн цагаан толгой” нэртэй MV-021183 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийг “Түүчээ тэрэг” ХХК-д АМГТГ-аас 2018 оны 09-р сарын 28-ны өдөр олгосон. “Түүчээ тэрэг” ХХК нь “Зүүн цагаан толгой” нэртэй алтны шороон ордыг түшиглэн уурхай, үйлдвэр байгуулж орон нутгийн нийгэм, эдийн засагт дорвитой хувь нэмэр оруулсан компани болохоор зорин ажиллаж байна.

“Зүүн цагаан толгой” алтны шороон ордод 2017 онд хийсэн хайгуулын ажлаар алтны шороон ордын бодитой боломжтой (В+С) зэрэглэлийн нөөцийг шлихээр 112.11 кг, химийн цэврээр 98.66 кг, үүнээс бодитой (В) зэрэглэлийн нөөцийг шлихээр 110.42 кг, шлихээр 97.17 кг, боломжтой (С) зэрэглэлийн нөөцийг шлихээр 1.69 кг, химийн цэврээр 1.49 кг тогтоосон ба нөөцийн блокуудыг дунджаар 638.78 мг/м^3 , хуулах хөрсний дундаж зузааныг 3.47 м-ээр гэж тооцоолсон байна.

Ордын ТЭЗҮ-н тодотголыг “СЕНОТ КОНСАЛТИНГ” ХХК-н боловсруулсан ба ордыг ашиглах арга, ашиглалтын системийн хувьд ордын геологийн тогтоц дээр тулгуурлаж ил аргаар, дотоод овоолготой, авто тээвэртэй олборлох ашиглалтын системийг сонгосон. Тухайн ашиглалтын системүүдийн онцлог, нутаг орны дэд бүтэц зэргийг үндэслэн урьдчилан дүгнэвэл харьцангуй бага хүчин чадалтай алт олборлох уулын үйлдвэр орон нутагт бий болох юм.

1.1. Ерөнхий мэдээлэл

Төслийн нэр:

- “Зүүн Цагаан Толгой” Алтны шороон орд ын ил уурхайн 2026 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллагын нэр:

- “Түүчээ Тэрэг” ХХК
 - Улсын бүртгэлийн дугаар: 9011028020
 - Регистрийн дугаар: 2773791

Аж ахуй нэгжийн албан ёсны хаяг, утас

- Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 3-р хороо, 2-р хороолол, 70 байр 57 тоот
- 88116280, 89118883

Төслийн товч танилцуулга, хүчин чадал

- Зүүн Цагаан Толгой нэртэй MV-021183 тоот тусгай зөвшөөрөлтэй талбайн нөөцийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2017 онд хийсэн хайгуулын ажлаар алтны шороон ордын бодитой боломжтой (В+С) зэрэглэлийн нөөцийг шлихээр 112.11 кг, химийн цэврээр 98.66 кг, үүнээс бодитой (В) зэрэглэлийн нөөцийг шлихээр 110.42 кг, шлихээр 97.17 кг, боломжтой (С) зэрэглэлийн нөөцийг шлихээр 1.69 кг, химийн цэврээр 1.49 кг тогтоосон ба нөөцийн блокуудыг дунджаар 638.78 мг/м³, хуулах хөрсний дундаж зузааныг 3.47 м-ээр гэж нөөцийг ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлсэн байна.
- Төсөлийн ТЭЗҮнэлгээний тодотголоор үйлдвэрийн нөөцийг бодохдоо ашиглалтын үеийн хаягдал 0%, бохирдлыг 22%-аар авч тооцсон ба ордыг 2 жилийн хугацаанд ашиглах бөгөөд энэ хугацаанд 351.94 мян.м³ хөрс хуулж, магадалсан В үйлдвэрлэлийн нөөцөд шилжүүлэн 82.83 мян.м³ элс 36.22 кг алт олборлохоор төлөвлөсөн байна. Жилийн хүчин чадал дунджаар 42 мян.м³ бөгөөд хөрс хуулалтын итгэлцүүр 3.25 м³/м³.

- Байгаль орчинд сөрөг нөлөөлөл

Төслийн зорилго

багатайгаар ил аргаар ашиглан
олборлолт явуулахад оршино.

- 2 жил

Төслийн үргэлжлэх хугацаа


1.2. Төслийн байршил

Зүүн Цагаан толгой” орд нь засаг захиргааны хувиараар Завхан аймгийн Ургамал сумын нутагт хамаарах ба Улаанбаатар хотоос баруун хойш 1250 гаруй км, Завхан аймгийн төвөөс БХ 225км, Ургамал сумын төвөөс баруун урагш 27км зайд байр зүйн зургийн М-46-128-Г, М-46-129-В дугаартай хавтгайнуудыг дамнан байрлана.

- Талбайн хэмжээ: 260,49 гектар

Хүснэгт 1. Төслийн талбайн булангийн цэгүүд						
№	Уртраг (Градус)	Уртраг (Минут)	Уртраг (Секунд)	Өргөрөг (Градус)	Өргөрөг (Минут)	Өргөрөг (Секунд)
1	94	0	10	48	20	10
2	93	59	50	48	20	10
3	93	59	50	48	23	35
4	94	0	10	48	23	35

Зураг 1. Төслийн талбайн байршил



1.3. Уурхайн жилийн хүчин чадал, горим ба ашиглалтын хугацаа

1.3.1. Уурхайн жилийн хүчин чадал

2026 онд манай компани нь Зүүн Цагаан Толгой алтны шороон ордоос 49.22 мян.м³ элс баяжуулж дунджаар 16.62кг алт олборлохоор 2026 оны уулын ажлын төлөвлөгөөнд тусгаад байна.

1.3.2. Уурхайн ажиллах горим ба ашиглалтын хугацаа

Ордыг ил уурхайн аргаар экскаватор авто тээвэртэй ашиглалтын системээр улирлын чанартай ашиглах юм. Тухайн газар орны уур амьсгалын байдалд үндэслэн уулын ажлыг цас ханзарч газар гэсэх үеэс цас орох хүртэл буюу 7-р сарын 20-наас 10-р сарын 1 хүртэл явуулах боломжтой гэж үзлээ. Уулын бэлтгэл ажлыг 07-р сарын 10-ээс 7-р сарын 20 хүртэл, хөрс хуулах ажлыг 07-р сарын 20-аас 10-р сарын 01 хүртэл, элс олборлох ажлыг 7-р сарын 25-наас 10-р сарын 01 хүртэл, элс угаах ажлыг 07-р сарын 21-ноос 10-р сарын 01 хүртэл явуулах боломжтой гэж үзэж байна.

Хүснэгт 2. Ил уурхайн хүчин чадал ажиллах горим						
Д.д	Хугацаа	Бэлтгэл ажил	Хөрс хуулах ажил	Элс олборлох ажил	Элс угаах ажил	Уурхай нийт
1	Жилд ажиллах хоног	10	70	65	65	80
2	Баяр ёслол, амралтын өдөр		0	0	0	0
3	Цаг агаарын болзошгүй саатал	2	5	5	5	5
4	Засвар үйлчилгээ	3	5	5	5	5
5	Ажиллах боломжит хоног	11	60	55	55	70
6	Ажиллах боломжит цаг	110	1,200	1,100	1,100	1,400
7	Хоногийн ээлжийн тоо	1	1	1	1	1
8	Ээлжийн үргэлжлэх хугацаа, цаг	10	12	12	12	12
9	Цаг ашиглалтын коэффициент	0.75		0.83		0.80

1.3.3. Ашиглалтын систем

Ордыг иж бүрэн элсний хаягдалгүй ашиглахын тулд 2026 оны 07 сарын 10–аас ордын дунд хэсгээс В-11 нөөцийн хэсэгшлийн урд хэсгээс нээж ашиглана. Энэ хэсэгт хөрсний зузаан харьцангуй бага бөгөөд 10,6 м-ийн орлын өргөнтэй ил уурхай үүсгэн хөрсийг гадаад овоолгод байршуулан ажлын талбай үүсгэнэ.

Бэлтгэл ажлын хүрээнд ил уурхай, шимт хөрсний гадаад овоолго, хуурайгаар угаах төхөөрөмжийн талбайн шимт хөрсийг хуулах, баяжуулах үйлдвэрийн элсний нөөцийг бэлтгэх, баяжуулах үйлдвэрийн талбайг байгуулах угсрах зэрэг ажлууд орно.

Шимт хөрсний овоолгыг нөхөн сэргээлтийн ажилд хэрэглэх юм. Уг шимт хөрсний овоолгыг ил уурхайн хүрээг даган байршуулна.

- 2026 онд В-11-ээс В-13, В-19 аас В-20 болон С-24 гэсэн 6 ш блокуудад олборлолтын ажил явуулж уурхай 187.72 мян.м³ хөрс хуулж, 49.22 мян.м³ элс угаан 16.62 кг алт цэврээр олборлоно.

Уурхайд хөрс хуулж овоолох, элс олборлох, олборлосон элсийг хуурайгаар баяжуулах гэсэн үндсэн процессууд явагдана. Мөн уурхайн ажлыг тасралтгүй хэвийн явуулахын тулд бусад туслах ажлууд үүний дотор ажлын хэмжээг харгалзах ажлыг хамруулж байна.

Ил уурхайн уулын ажлын эхэн үед хучаас хөрсийг экскаватор ашиглан олборлолтын талбайн гадна шууд овоолго хийнэ. Уулын ажлын ахилт нь нөөцийн хэсэгшлийн дагуу урдаас хойшоо чиглэлтэй байх ба хөрс хуулалтын ажлыг түвшин бүрд хөндлөн орлоор хийж улмаар элсийг олборлон ул чулуулагт хүргэж дотоод овоолго хийх ажлын талбай гармагц дотоод овоолгод хөрсийг хурааж ажиллах юм. Хөрс хуулалтын ажлын доголын өндөр 1.32-5.0 м байна.

2. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2.1. Байгаль орчин, нийгэм-эдийн засгийн төлөв байдлын товч танилцуулга


Уул зүй: Тус талбай нь Монгол улсын физик газарзүйн мужлалаар Хангайн уулархаг мужийн баруун захад, Их нууруудын хотгорын зүүн хэсэгт орших бөгөөд уулс нь газрын гадаргуугын хэлбэр дүрсээрээ ерөнхийдөө говь хээрийн бүсийн дунд зэргийн уулсын дүүргийн далайн түвшнөөс дээш 1300-1600 м өндөртэй уулсуудтай.

Эдгээр уулс нь урт удаан хугацааны говийн хуурай уур амьсгалаас шалтгаалан U, Y хэлбэрийн жалга, сайруудаар хэрчигдсэн хуваагдсан биеэ даасан жижиг салбар уулсуудыг үүсгэсэн байдаг.

Энэ дүүрэг нь Монгол улсад томоохонд тооцогдох Их нууруудын хотгорын мужийн Монгол элсний дэд мужид харъяалагдах Бор Хар элс, Монгол элсний хооронд орших учир жалга, судаг, хуурай сайр, хөндий хоолойнууд нь нуур, голын гаралтай элсний зузаан давхаргаар хучигдсан байдаг.

Судалгааны талбай нь геологийн ажил явуулахад хүндрэл багатай, нэвтрэлт сайтай дүүрэг гэгдэх боловч уулс нь хад, асга, гүн гуу жалга ихтэй, хүчтэй хэрчигдсэн эгц хажуутай, харьцангуй өндөршил ихтэй, мөн сайруудын ёроол нь сул хайрга болон элсээр зузаан хучигдсан зэргээс шалтгаалан нэвтрэхэд ихээхэн хүндрэл учруулаж, цаг хугацаа ихээхэн шаардагддаг.

Зураг 2. Завхан аймгийн уул зүй



Цаг уур: Ургамал сумын нутаг дэвсгэр нь уур амсгалын хувьд манай орны бүх нутгийн адил эх газрын эрс тэс уур амьсгалтай бөгөөд өвөл, зун нь богинохон, хавар, намар ни урт, халуун хүйтний хэлбэлзэл их байна.


Хүйтний улирал үргэлжлэх хугацаа богино, 10-р сарын сүүлчээс хүйтэрч эхлэн хамгийн хүйтэн үе нь 12, 1-р сарын дунжаар -32-35C хүрч цас бага ордог учир зөвхөн уулын ар, бэл, ам, хөндийнүүдэд цасан бүрхүүл тогтсон байна. Зун нь богино боловч их халуун өнгөрч дулаан үе 6-8-р сард +32-+35C байдаг. Харин хавар, намрын улиралд уур амьсгал нь тогтворгүй, салхины хүч ихэсч, элсээр шуурдаг.

Жилийн аль ч улиралд баруун хойд зүгийн салхи зонхилж дундаж хурд нь 5-12м/с хүрдэг бөгөөд салхины жилийн ба сарын хэлбэлзэл нь 4,5,9-р саруудад салхилалт хамгийн их, 6-р сарын сүүлчээс 8-р сарын эх хүртэл харьцангуй тогтуун 3-4 м/с хурдтай байна. Хур тунадас харьцангуй бага, жилд унах хур тунадасны хэмжээ дунджаар 100-150мм-ээс хэтрэхгүй. Зарим жил хур тунадсаар гачигдан гандуу байх үе ч тохиолдоно.

Ус зүй: Хайгуулын талбай нь гидрогеологийн улирлын хомс тэжээлтэй мужид хамаарагдах бөгөөд усан хангамжын хувьд тааруухан, усны горим нь тогтворгүй, хур тунадас уналтын хэмжээнээс шууд хамаардаг, усан сүлжээ муу хөгжсөн газар юм. Ордын хэмжээнд байнгын урсгалтай гол, горхи, булаг, шанд зэрэг хөрсөн дээрхи ус байхгүй зөвхөн талбайн хойд талаар 27км зайтай Хүнгүйн гол урсдаг.

Хүнгүйн гол нь Хангайн нурууны баруун салбар уулаас эх аван урссаар Айраг нуурт цутгадаг. Түүний урт 250 км, өргөн нь 30-40 м, гүн нь 0.3-0.6 м, урсгалын хурд 1,0м/с орчим байна. Голд ганц нэг гарам байдаг боловч ёроолдоо сул элс, лаатай тул машин гатлахад бэрх бөгөөд ус нь элсний хольцтой урсдаг боловч ундны хэрэгцээг бүрэн хангадаг. Голын орчим дахь тэвш хэлбэрийн өргөн хөндий, хуурай сайруудаар бороо хур ихтэй түр зуурын урсагал ус урсдаг.

Зураг 3. Завхан аймгийн усны ай сав



Ан амьтан: Энэ нутагт туурайтан амьтдаас хар сүүлт байсан гэдэг боловч сүүлийн жилүүдэд харагдахаа больсон байна. Харин өндөр уулын бүсэндээ цөөн тоогоор аргаль янгир байдаг байна. Махчин амьтдаас чоно, үнэг, хярс амьдрахаас гадна хэвлээр явагч могой, гүрвэл нилээд элбэг үзэгдэнэ.

Хөрс ургамал: Хайгуулын талбай нь ботаник-газарзүйн мужлалаар Евроазийн хээрийн мужийн Дагуур Монголын (Төв Азийн) дэд муж дах Говийн умард цөлөрхөг хээрийн мужийн Их нууруудын хотгорын дэд мужид хамаарагдах бөгөөд энд говь хээрийн бүсийн бор өнгийн хайргархаг, дайргархаг элс, элсэрхэг хөрс голлон тархана.

Энэ бүсэд зонхилох бор хөрс нь ялзмагийн зүйл багатай, бага зузаантай (5-10 см орчим) чийг хадгалалт муутай байдаг.

Хонхор газар голын эрэг орчмоор давсархаг хөрс, хужир марз элбэг тархсан бөгөөд энд дэрс ургана. Ургамлын бүрхэвч сийрэг, тачир учир энд тэнд хэсэг хэсгээр ургана. Тайлбай нь ургамлын хувьд ус, чийг бага шаарддаг халуунд тэсвэртэй бутлаг, дэрслэг ургамал зонхилох бөгөөд хазаар өвс, ширх, агь зэрэг хээрийн ургамалын зэрэгцээгээр бор шаваг, хялгана, ортууз, баглуур ургана.

Дүүргийн дэд бүтэц, эдийн засгийн хөгжлийн хэтийн төлөв: Төслийн талбайд хамгийн ойр орших суурин газар нь Завхан аймгийн Ургамал сумын төв бөгөөд зүүн хойш авто замаар 27 км-т байдаг.

Тус сум нь зүүн талаараа Завханмандал, урдуураа Дөрвөлжин, баруун талаараа Увс аймгийн Завхан сумдтай хил залган оршдог ба 349.2 мянган га талбайтай, мал аж ахуй, газар тариалан эрхлэн хөгжүүлж ирсэн ба одоогийн байдлаар 332 өрхтэй, 1214 хүн амтай, 120 мян толгой малтай, үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж 14, төсөвт 6 байгууллага, банкны 2 салбар үйл ажиллагаа явуулж мянгат малчин 20 болж малчин өрхийн тоо жилээс жилд өсөн нэмэгдэж үйлчилгээний салбар хүрээ өргөжин тэлсээр байна.

Төслийн талбайн орчим хүн амын суурьшил харьцангуй сийрэг хэдий боловч суурин газартаа хүн амын суурьшил арай нягт байна. Үндсэн оршин суугчид нь халхууд байх ба нийт иргэдийн ихэнхи нь мал аж ахуй эрхэлж, түүнийхээ ашиг шим, түүхий эдээр амьдрал, ахуйгаа залгуулдаг. Малчид нь таван хошуу малаас бог малыг арай түлхүү үржүүлдэг.

Сумын төвд “МЦХ” ХКомпанийн харьяа холбооны салбар байхаас гадна Мобиком, Юнител, Жи-Мобайл компаниудын үүрэн телефоны үйлчилгээтэй.

Ургамал сумын төвд эмнэлэг, олон тооны жижиг дэлгүүрүүд, 9 жилийн дунд сургууль, хүүхдийн цэцэрлэг, цахилгаан холбоо, ШТС зэрэг үйлчилгээний байгууллагуудтай.

Зам харилцааны хувьд Улаанбаатар-Улиастай-Ургамалын чиглэлийн II зэрэглэлийн замтай бөгөөд өөр бусад аймгийн төв, сумдын төвтэй холбогдсон шороон замуудтай.

Мөн хайгуулын ажил явуулхад жилийн аль ч улиралд хаагуур ч явахад боломжтой жижиг замуудтай.

3. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

3.1. Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт

Уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэндэд нөлөөлөх гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 3. Төслийн байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл		
Д.д	Орчны бүрэлдэхүүн хэсэг	Сөрөг нөлөөлөл
1	Агаар орчин	• Хөрс хуулах, олборлолт явуулах үед тоосжилт болон дуу чимээ, доргио чичиргээ үүсэх • Тээврийн хэрэгсэл, хүнд даацын машин механизмын түлшний шаталтаас хорт хий ялгарах • Хог хаягдлын цэг, уламжлалт ариун цэврийн байгууламж, бохир усны цооногоос орчны агаарт физик бохирдол үүсэх
2	Хөрс орчин	• Хөрс хуулах, олборлолт явуулах үед хөрсөн бүрхэвч эвдрэх, газрын хэлбэр, төрх өөрчлөгдөж ухаш үүсэх • Хүнд даацын машин, техникийн засвар үйлчилгээнээс гарсан хаягдал тос, масло хөрсийг хүнд металаар бохирдуулах • Шимт хөрсний овоолгын үржил шим алдагдах
3	Гүний ус	• Уурхайн ус хэрэглээний улмаас усны нөөц багасаж болзошгүй • Ил задгай хаясан хог хаягдал гүний усыг бохирдуулж болзошгүй
4	Ургамлан нөмрөг	• Хөрс хуулалтаас үүсэх шимт хөрс болон хоосон чулуулгийн овоолгын доорх ургамлан нөмрөг дарагдах • Уурхайн үйл ажиллагаа, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний улмаас ургамлан нөмрөг устах, тоосонд дарагдах
5	Амьтны аймаг	• Тээврийн хэрэгслийн хөдөлгөөн зэрэг уурхайн үйл ажиллагааны улмаас ан амьтны амьдрах орчин өөрчлөгдөх, дайжих • Зэрлэг ан амьтан уурхайн талбайд орж ирсэн үед ухсан нүхэнд унаж бэртэх нөхцөлтэй
6	Түүх, соёлын өвд үзүүлэх нөлөө	• Уурхайн үйл ажиллагааны улмаас түүх, соёлын үнэт зүйл устаж үгүй болох
7	Бусад	• Хөдөлмөр хамгаалал болон сургалт мэдээллээр уурхайн ажилчдыг бүрэн хангаагүйн улмаас бэртэж гэмтэх • Хүний санамсар болгоомжгүй үйл ажиллагааны улмаас галын аюул үүсэх • Хүчтэй салхи шуурга, аянга цахилгаан, газар хөдлөлт, түймэр зэрэг байгалийн гамшигт үзэгдэл тохиолдсон үед уурхайн хэвийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх

4. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Зорилго: Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-ний гол зорилго нь төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах хэмжээг төлөвлөхөд оршино. Ингэхдээ тухайн арга хэмжээ бүрийг төсөл хэрэгжүүлэгч нь хэрэгжүүлж чадахуйц, бодитойгоор төлөвлөх нь чухал.

Гол зорилтууд:

- Байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд болон хүний эрүүл мэнд, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулахад зайлшгүй хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх;
- Төслийн үйл ажиллагаанаас агаар, хөрс, усан орчин болон ажлын байрны нөхцөлд хэрхэн нөлөөлж байгаа талаар хяналт шинжилгээ явуулах арга хэмжээг төлөвлөх

Хүснэгт 4. 2025 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал		
Д.д	Ажлын нэр	Зардал (₮)
1	Сөрөг нөлөөллийг бууруулах хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	2,340,000
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	11,500,000
3	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөний зардал	ҮАЗардалд
4	Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох төлөвлөгөө	-
5	Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
6	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	600,000
7	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	1,100,000
8	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	2,350,000
9	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	ҮАЗардалд
10	Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	900,000
	НИЙТ ЗАРДАЛ	18,790,000

5. Сөрөг нөлөөллийг бууруулах хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн үйл ажиллагаанаас үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, түүнээс урьдчилан сэргийлэх үүднээс дараах арга хэмжээг бид хэрэгжүүлнэ.

Хүснэгт 5. Төслийн сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, арилгах, бууруулах арга хэмжээ					
№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Нийт зардал (₮)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө					
1	Төслийн үйл ажиллагаа, гадаад дотоод тээвэрлэлт, барилга байгууламж шинээр барих, газар шорооны ажил хийх	Төслийн талбайн тоосны хуримтлал, түүнд агуулагдах хүнд элементүүдийн найрлагыг тогтоох, нийт тоосны хэмжээг хянах	Дотоод төлөвлөгөөгөөр	Төслийн үйл ажиллагааны туршид шаардлагатай тохиолдолд	Агаарын тухай хууль, MNS 4585:2026 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага Ажлын байрны агаарын эрүүл ахуйн шаардлага: MNS 4990:2010, MNS 0017-2-3 16:1998 MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS ISO 226:2003 Дуу чимээ- хэвийн норм, түвшний хэмжээ
		Төслийн талбайд зорчих нийт тээврийн хэрэгслүүдэд хурдны хязгаар тогтоох зорилгоор трассын дагуу төслийн талбайд тэмдэг, тэмдэглэгээ байршуулах	250.000	Төслийн үйл ажиллагааны туршид	
2	Төслийн үйл ажиллагаанд ашиглах техник, авто тээврийн хэрэгслийн дотоод шаталтын хөдөлгүүрээс хорт хий ялгарч агаар орчныг бохирдуулах	Төслийн үйл ажиллагаанд ашиглах нийт тээврийн хэрэгслүүдийг үзлэг оношилгоонд хамруулах, оношилгоонд тэнцсэн буюу шаардлага хангасан машин, техник ашиглах, тэдгээрийн агаарын бохирдлын төлбөр төлөх	440.000	Төслийн үйл ажиллагааны туршид	

		механизм, техник хэрэгслээс гарах химийн хорт бодис бүхий хий, утааг багасгахын тулд ашиглаагүй үед унтраах	Дотоод төлөвлөгөөгөөр	Төслийн үйл ажиллагааны туршид	
3	Дуу шуугианы бохирдол үүсэх	Дуу шуугиан ихтэй орчинд ажиллах үед ажилчдыг чихэвч болон бусад төрлийн аюулгүй ажиллагааны хамгаалах хэрэгслүүдээр шаардлагатай тохиолдолд хангах	Дотоод төлөвлөгөөгөөр	Төслийн үйл ажиллагааны туршид	
4	Дотоод орчинд агаар бохирдуулагч хий болон тоосонцор хуримтлагдах	Ажлын байр, далд уурхайн талбайн дотоод орчин, амралтын байруудын дотоод орчинд агааржуулалтыг тогтмол хийх, шаардлагатай хэсгүүдэд агааржуулалтын хоолой, агааржуулах систем суурилуулах	Дотоод төлөвлөгөөгөөр	Төслийн үйл ажиллагааны туршид	
Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээний төлөвлөгөө					
1	Ордын ашиглалтын ажилд ашиглагдаж буй машин техникийн засвар үйлчилгээний цэг болон жолоочийн хариуцлагагүйгээс нефтийн бүтээгдэхүүн алдагдаж хөрсний усыг бохирдуулах	Ажилтан албан хаагчдад энэ чиглэлийн анхааруулга санамж өгөх, засварын газар, автозогсоол, ажилчдын тосгон зэрэг шаардлагатай газруудад самбар гаргах, мэдээллийн хуудас байрлуулах	500.000	Төслийн үйл ажиллагааны туршид	МУ-н Усны тухай хуулийн 22-р зүйл, 24-р зүйл
2		Засвар үйлчилгээ, шатах тослох материалаар машин техникийг цэнэглэхдээ ШТМ алдагдсан ч хөрсөнд нэвчихээргүй байх аюулгүй ажиллагааны арга хэмжээ авч байх /пелонк дэвсэх, бетондсон талбай бэлтгэх зэрэг/	600.000	Төслийн үйл ажиллагааны туршид	

3		ШТМ хөрсөнд алдагдсан үед хусаж авах, саармагжуулах, цэвэрлэх арга хэмжээ авах, шаардлагатай багаж материалыг бэлтгэх /элс хайрга, хүрз,ус, саармагжуулагч бодис гэх мэт/	400.000	Төслийн үйл ажиллагааны туршид	
Газрын хэвлий, хөрсөн бүрхэвчид учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээнүүд					
1	Уурхайн талбайд хөрс эвдрэлд өртөх	Ашиглалт дууссан талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх, Хөндөгдсөн талбайг түрж тэгшлэх	Нөхөн сэргээлтийн зардалд тусгагдсан	Төслийн үйл ажиллагааны туршид	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль -7.2.1
2	Хог хаягдлын цэг болон уурхайн хэсгүүдээс хөрс бохирдолд өртөх	Бохирдсон талбайн хэмжээг тодорхойлох, бохирдол үүссэн, эх үүсвэр илэрсэн тохиолдолд цэвэршүүлэх, бохирдсон хөрсийг нүүлгэн шилжүүлэх	Дотоод төлөвлөгөөгөөр	Төслийн үйл ажиллагааны туршид	Хөрс хамгаалах, газрын доройтлыг бууруулах үндэсний хөтөлбөр 3.3.12 MNS 17.5.1.19-92 - Эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн шаардлага MNS 5916:2008, MNS5918:2008, MNS 3297:1991
3	Өнгөн хөрсний овоолго, хаягдалд хөрс дарагдах	Үржил шимт хөрсийг хусаж зайлуулах, өнгөн хөрсний овоолго байгуулах, салхи усны эвдрэлд бага өртөхөөр зохион байгуулах, 2 жилээс дээш хадгалах бол хажууг ургамалжуулах, өнгөн хөрсний овоолгын чанарыг хянах, дээж авах	Дотоод төлөвлөгөөгөөр	Төслийн үйл ажиллагааны туршид	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль -7.2.3 Хөрс хамгаалах, газрын доройтлыг бууруулах үндэсний хөтөлбөр 3.3.12 MNS 17.5.1.19-92 - Эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн шаардлага

4	Шороон замаар хөрс эвдрэх, дарагдах	Уурхайн тээвэрлэлтийн замын чиглэл батлах, чиглэл, хурд заасан тэмдэг байршуулах, Тоосжилт бууруулах	150.000	Төслийн үйл ажиллагааны туршид	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль - 7.2.5
Ургамлын нөмрөгт учруулж болзошгүй сөрөг нөлөөг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө					
1	Байгалийн ургамал, доройтох, зарим ургамлын ургах чадвар алдагдаж устах	Уурхайлалтын явцад олон тооны машин техник ажиллах тул тэдгээрийн хөдөлгөөний чиглэл явах маршрутыг нарийн төлөвлөж, олон салаа зам үүсгэхгүй байхыг анхааруулах, жолооч ажилчдад байгаль орчинтой зөв харьцаж, хамгаалах талаар зөвлөгөө сургалт явуулж, хяналт тавих;	Дотоод төлөвлөгөөгөөр	Төслийн үйл ажиллагааны туршид	Хөдөлмөр, аюулгүй ажиллагааны дотоод дүрэм, стандарт
		Бэлчээр тэжээлийн үнэт ургамлуудыг хамгаалах, тэдгээр ургамлыг тарих, нөхөн сэргээх ажлыг мэргэжлийн байгууллагаар өндөр түвшинд гүйцэтгүүлэх	Нөхөн сэргээлтийн зардалд тусгагдсан	Төслийн үйл ажиллагааны туршид	MNS6253-2: 2011, MNS 5994: 2009, MNS 6263: 2011
Амьтны аймагт учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө					
1	Амьтдын амьдрах орчин доройтох, идэш тэжээлийн хомсдол буй болох	Биотехникийн арга хэмжээ авах	Нийгмийн хариуцлагын хүрээнд	Төслийн үйл ажиллагааны туршид	Нийгмийн хариуцлагын хүрээнд
2	Хууль бус агнуурт өртөх	Хууль бус агнууртай тэмцэхэд орон нутагт дэмжлэг үзүүлэх, мэдээлэх	Нийгмийн хариуцлагын хүрээнд	Төслийн үйл ажиллагааны туршид	Амьтны тухай хууль
		Нийт зардал	2340.000		

6. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Хүснэгт 6. Төслийн талбайд техникийн нөхөн сэргээлт хийх арга хэмжээ						
Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	Нөхөн сэргээх үйл ажиллагаа	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал (₮)	Нийт зардал (₮)	Хэрэгжүүлэх хугацаа
Техникийн нөхөн сэргээлт	Дотоод овоолго болон ковшоор түрж тэгшлэх	га	5.05	1,683,168	8,500,000	2026 онд олборлолт хийгдсэн талбайд
Биологийн нөхөн сэргээлт	Шимт хөрсийг ковшоор түрж тараах	га	5.05	594,059	3,000,000	2026 онд Техникийн нөхөн сэргээлт хийгдсэн талбайд
	Нийт				11,500,000	

7. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

2026 онд манай компаний зүгээс орон нутгаас санал авч Ургамал суманд байгаа эвдэгдсэн талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажлийг хийхээр төлөвлөөд байна.

8. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

Уг төслийг хэрэгжүүлэхэд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох үйл ажиллагаа явагдахгүй болно.

9. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн талбайд 2017 оны 05 сарын 10-15 ны хооронд тусгай эрх бүхий МУИС-н ШУС антропологи археологын тэнхэмээр талбайн хэмжээнд бүхэлд нь Археологийн судалгааг хийлгэсэн ба ашиглалтын талбайн хэмжээнд ямар нэгэн түүх соёлын дурсгалт зүйл болон археологи, палеонтологийн олдвор илрээгүй болно.

Хүснэгт 7. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө							
Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8
Археологийн дурсгал	Хэрэв уурхайн	Уурхайн ашиглалтын	-	ҮАЗардалд		Үйл ажиллагааны турш	Соёлын өвийг хамгаалах тухай хууль
Палеонтологийн дурсгал	үйл ажиллаг	нын нийт					
Нийт							

10. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 8. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө						
№	Болзошгүй аюул осол	Урьдчилан сэргийлэх арга хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал (₮)	Нийт зардал (₮)	Хэрэгжүүлэх хугацаа
1	Байгалийн давагдашгүй хүчин зүйл	Байгалийн аюул гамшгийн үед авах арга хэмжээний талаар сургалт зохион байгуулах	1 удаа	ҮАЗардалд	ҮАЗардалд	Жилд 1 удаа
2	Цахилгаан хэрэгслийн аюул, гал түймэр	Ажиллагсдыг цахилгаан хэрэгсэлтэй харьцаж ажиллах арга ажиллагаанд сургах; Гал унтраах хэрэгслийг зохих газруудад байрлуулах	20 ш	30,000	600,000	Жилд 1 удаа
	Нийт:				600,000	

11. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

2026 оны хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хүрээнд уурхайн ахуйн хог хаягдалыг кемп дээр тусгайлан байгуулсан хогийн цэгт байрлах төмөр боошигнуудад ангилан хийж дүүрмэгч Ургамал сумын тамгын газартай гэрээ хийж сумын төвийн нэгдсэн хогын цэгт сард нэг удаа тээвэрлүүлэхээр төлөвлөөд байна.

2026 онд Уурхайн нийт техник тоног төхөөрөмжүүдээс гарсан хаягдал тос масло тосолгооны материалыг кемп дээр засварын талбайн хажууд баршуулсан төмөр боошигнуудад савлан хадгална.

2026 онд улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй тусгай зөвшөөрөл бүхий Төгс Билэг Инженеринг ХХК-тай гэрээг хийсэн ба гэрээний дагуу уурхай буух үед тээвэрлүүлэн дахин боловсруулалтанд оруулхаар болсон.

Хүснэгт 9. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө								
№	Хамрах хүрээ	Арга хэмжээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (₮)	Тоо хэмжээ	Нийт зардал (₮)	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Ахуйн хог хаягдал								
1	Түүчээ тэрэг ХХК-ийн төслийн талбай	Нийт уурхай дээр хуримтлагдсан хог хаягдлыг сумын төвийн нэгдсэн хогын цэгт тээвэрлэн хаях	Удаа	300,000	1	300,000	Жилд 1 удаа	МУ-н Хог хаягдлын тухай хуулийн 10-р зүйл, Хог хаягдлын улсын тоо бүртгэл хөтлөх журам
Аюултай хог хаягдал								
2	Түүчээ тэрэг ХХК-ийн төслийн талбай	Ашигласан тос, аккумулятор, батарей, хуучин дугуй, шатах, тослох материалын сав г.м аюултай хаягдлыг зохих журмын дагуу Аюултай хог хаягдлыг дахин боловсруулах, тээвэрлэх, цуглуулах, устгах эрх бүхий газарт нийлүүлэх	Литр	800	1000	800,000	Жилд 1 удаа	Аюултай хог хаягдал тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах журам
3	Ахуйн хог хаягдал болон аюултай хог хаягдлын үүссэн болон хуримтлагдсан хэмжээг нэр, төрөл бүрээр сар, жилд гарах нийт тоо хэмжээг бүртгэнэ.	Батлагдсан маягт, “Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт”-ын дагуу хог хаягдлын тоо бүртгэлээ хөтөлж, тогтоосон хугацаанд Ургамал сумын Засаг даргад хүргүүлнэ.		Уурхайн үйл ажиллагааны зардалд тусгах		Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 11 дүгээр сарын 12ны өдрийн А/428 дугаар тушаалын хавсралт Хог хаягдлын улсын мэдээллийн нэгдсэн сангийн толгтолцоо, жил бүрийн 12 сарын 15-ны дотор хүргүүлэх.		
Нийт:						1,100,000		

12. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

2026 оны Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт нөлөөлөлд өртөх болон өртөж болзошгүй байгаль орчны бүрдэл хэсгүүд, тэдгээрийн төлөв байдлыг тодорхойлох үзүүлэлтүүд, уурхайн талбайн орчинд амьдардаг, нөлөөлөлд өртөх нутгийн иргэдийн амьжиргаа, нийгмийн болон эрүүл мэндийн байдлыг илтгэх гол үзүүлэлтүүд, тэдгээрт хэмжилт, дээжлэлт хийх шинжилгээний аргууд, хяналтын цэгийн байршил, хяналт хийх хугацаа ба давтамжийг БОНҮнэлгээнд тусгасаны дагуу тодорхойлон орууллаа.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд уурхайн олборлот явуулж байгаа мөн нөхөн сэргээлт хийсэн талбай болон кемпийн хогийн цэг, үйлдвэрлэлийн ус авдаг худгын ойролцоо цэг сонгон 5 ш хөрсний дээж авч хүнд металын шинжилгээ. Сумын төвд байрлах уурхайн ундны ус авдаг худаг болон уурхайн үйлдвэрлэлийн ус авдаг худгуудаас усны дээж авч Завхан аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвөөр шинжилгээ хийлгэх ба мөн орон нутгийн тусгай эрх бүхий байгууллагаар хяналтийн ажлийг нэг удаа хийлгэнэ.

Хүснэгт 10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр						
№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Нэгжийн зардал (₮)	Нийт зардал (₮)	Баримтлах стандарт, арга аргачлал
1	Агаарын чанар — NO ₂ , SO ₂ ,TPS PM2.5, PM10 Дуу шуугиан	1. Кемп 2. Карьер зонхилох салхины доор 3. Хөрсний овоолго дээр 4. Авто машин зогсоол, засварын газар	Жил бүр 1 удаа	850,000	850,000	MNS 4585:2025 Агаарын чанар, техникийн ерөнхий шаардлага
2	Хөрсний хүнд металлын зарим элементүүд (Pb, Zn, Cd, Cr, Ni, Co)	Шатахуун түгээх цэгийн ойролцоо Уурхайн дам нөлөөллийн бүс. Байгалийн анхдагч шинж бүхий хөрсний хяналтын цэг Уурхайн үйл ажиллагааны нөлөөллийн бүс Кемпийн ойролцоо	Жил бүр 2 удаа	450,000	900,000	- УСТ 3298-90 Хөрснөөс шинжилгээнд дээж авахад тавигдах шаардлага - MNS 5850-2098-Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодисын ЗДХ - MNS 3310-91 - Хөрс. Хөрсний агрохимийн үзүүлэлтүүдийг тодорхойлох
3	Ундны болон Технологын усны бүрэн шинжилгээ, усан дахь хүнд металлын агууламж	Унд ахуйн хэрэглээний худгаас, уурхайн үйлдвэрлэлийн ус ашиглах худгаас	Жил бүр 2 удаа	300,000	600,000	MNS (ISO) 4867:1999 Усны чанар. Дээжийг боловсруулах, хадгалах зөвлөмж MNS 0900:2018 Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт
	Нийт				2,350,000	

13. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Төслийн хэрэгжилтийн үед авч хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын асуудал ихээхэн чухал үүрэгтэй юм. Удирдлага зохион байгуулалтын менежментийг БОНҮнэлгээнд тусгасаны дагуу дараах чиглэлд хандуулан төлөвлөгөөнд тусгалаа.

- ✓ Байгаль орчны асуудал хариуцаж ажиллах ажилтан, түүний үүрэг хариуцлага
- ✓ Байгаль орчны чиглэлээр орон нутгийн иргэд, олон нийттэй хамтран ажиллах ажлын чиглэл
- ✓ Ажилчдын дунд зохион байгуулах сургалт, танилцуулгын ажил, мэдээллийн самбар
- ✓ ХАБЭА-н чиглэлээр хийгдэх ажил

✓ Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний гүйцэтгэлд хяналт шинжилгээ хийлгэсэн дүнг заасан хугацаанд холбогдох байгууллагад хүргэж тайлагнах

Хүснэгт 11. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө					
№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь	Хариуцсан албан тушаалтан	Шаардлага
1. Хуулийн хэрэгжилтийг хангуулах					
1	БОМТ-нд тусгасан байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг тодорхой албан тушаалтанд хариуцуулан үйл ажиллагааг зохион байгуулах, дотоод журам тогтоож мөрдөх	Уурхайн үйл ажиллагааны зардалд тусгах	Төслийн нийт хугацаанд	Уурхайн удирдлага	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 31.7 дугаар заалт
2	Байгаль орчны Аудит хийх	Гэрээний дүнгээр	2027	Уурхайн удирдлага	Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 101 дэх зүйл
2. Ажиллагсдыг чадавхжуулах					
3	Ажилчдыг ХАБ-ын сургалтад тогтмол хамруулах, чадавхжуулах	Уурхайн үйл ажиллагааны зардалд тусгах	Жил бүр	ХАБЭА	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай” хуулийн 27.3.4, 28.1.8-р заалт “Химийн хорт болон аюултай бодисын тухай” хуулийн 13.6 “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Сургалтын зохион байгуулалт үндсэн дүрэм” MNS 4969:2000 “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль”-ийн 14-р зүйл
4	Орон нутгийн онцгой байдлын хэлтэстэй хамтран ажиллах гэрээ байгуулж, гэнэтийн осол, эрсдэл, түүнээс хамгаалах талаар сургалт зохион байгуулах	Уурхайн үйл ажиллагааны зардалд тусгах	Жил бүр	Уурхайн удирдлага	
5	Шаардлагатай үед хэрэглэх иж бүрэн эмийн санг заавартай нь байрлуулах, тогтмол хугацаанд нөхөн сэлбэх	Уурхайн үйл ажиллагааны зардалд тусгах	Жил бүр	ХАБЭА	

14. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

Хүснэгт 11. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө						
№	БОМТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал (₮)	Хариуцах албан тушаалтан
1	Орон нутгийн байгаль орчны хэлтэс ба тухайн багийн ИНХ-д танилцуулах	Хэвлэмэл цаасан тайлан, илтгэл хэлбэрээр танилцуулна.	Төслийн үйл ажиллагааны танилцуулга болон Байгаль орчны менежментийн төлөвлөгөө хийж гүйцэтгэсэн ажил, хийхээр төлөвлөж байгаа ажлын талаарх дэлгэрэнгүй мэдээлэлтэй байна.	10-р сард	400,000	БОМ, Уурхайн дарга
2	Завхан аймгийн байгаль орчны газар	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан /Баримт бичгийн бүрдэл, хэвлэмэл хэлбэрээр тайланг хүргүүлнэ/		2026.11.01	500000	БОМ, Уурхайн дарга
3	БОУАӨЯ-ны ХБОБНГ-т	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулах /Баримт бичгийн бүрдэл, хэвлэмэл хэлбэрээр тайланг хүргүүлнэ		2026.12.01	ҮАЗардалд	БОМ, Уурхайн дарга
4		Нийт			900,000	

15. “ТЭР БУМ МОД” ХӨДӨЛГӨӨНИЙ ХҮРЭЭНД МОД ТАРИХ

2026 онд “Тэрбум Мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд манай компаний зүгээс Ургамал сумын төвд цэцэрлэгт хүрээлэнд ойн төгөл байгуулах ажлыг тусгай эрх бүхий байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлэхээр төлөвлөөд байна.

Хүснэгт 13. "Тэрбум мод" хөтөлбөрийн хүрээнд							
№	Зорилт	Суулгах модны төрөл	Талбайн хэмжээ	Суулгах модны тоо	Нэгжийн зардал (₮)	Нийт зардал (₮)	Хэрэгжүүлэх хугацаа
1	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд тарих мод	Улиас, бургас, Чацаргана гэсэн 3 төрлийн мод	1 га	2,000	15,000	30,000,000	2025.11.01
2	Нийт					30,000,000	

